




МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН
ХЭЭРИЙН ХУВЦАСНЫ ДААВУУ

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

MNS 6706 : 2018



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75%-иас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын үндэсний зөвлөл (СҮЗ)-өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш С.Цэцгээ, профессор Л.Удвал, “Аюулгүй хөдөлмөрийн үндэс” НҮТББ-ийн зөвлөх, доктор Д.Энхжаргал, Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Ариунбилэг нар боловсруулж, СХЗГ-ын мэргэжилтэн Ч.Пүрэвдулам “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: “Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандартад нийцүүлэн засварлав.

Уг стандартыг Текстилын техникийн хороогоор хэлэлцэн дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13348, ШХ-48

Утас: 266754, 263860,

Факс: (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn

Вэб сайт: www.estandart.mn,

www.masm.gov.mn

© СХЗГ, 2018

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 59.080.30

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн хээрийн хувцасны даавуу. Техникийн шаардлага

Specialty profile: Fabric for field clothes of employees
National emergency Management Agency. Technical requirements

MNS 6706 : 2018

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1. Хамрах хүрээ ба хэрэглэх хүрээ

1.1 Энэхүү стандарт нь Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дулааны болон хүйтний улиралд хээрийн нөхцөлд өмсөх зориулалттай хувцас бэлтгэхэд ашиглах даавуу материалд тавигдах ерөнхий техникийн шаардлагуудыг тогтооно.

1.2 энэхүү стандартыг хувцасны материал сонгох, иж бүрдүүлэх, үйлдвэрлэх, шалгахад хэрэглэнэ.

2. Норматив ишлэл

Энэ стандартын холбогдох бичлэгт дараах норматив баримт бичгүүдийг иш татав. Эдгээр хэвлэлд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь ишлэлийн нэгэн адил энэ стандартад хамаарна. Үүнд:

- ISO 15797 Нэхмэл. Ажлын хувцасны туршилтанд зориулсан үйлдвэрлэлийн угаалганы ба гүйцэтгэн боловсруулалтын аргууд,
- ISO 105-C06:1997 Нэхмэл. Будгийн тогтвор шалгах туршилтууд. Хэсэг C06. Гэрлийн нөхцөлд болон угаалгын газрын угаалганд будгийн тогтвор шалгах,
- ISO 105-B02:2002 Нэхмэл. Будгийн тогтвор шалгах туршилтууд. Хэсэг B02. Хиймэл гэрэлд будгийн тогтвор шалгах: Ксенон гэрэл ашигласан гандалтын туршилт,
- ISO 12947-3:2002 Нэхмэл бүтээгдэхүүн.Элэгдэл тэсвэрлэлт тодорхойлох арга
- EN 1413 Нэхмэл. Усан уусмалын рН тодорхойлох,
- EN 25077 Нэхмэл. Угаалгын болон хатаалтын дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох,
- EN ISO 3175-1 Нэхмэл. Хуурай цэвэрлэгээ ба эцсийн боловсруулалт. Хэсэг 1. Нэхмэл бүтээгдэхүүн ба хувцасны цэвэрлэгээнд тохирох байдлыг үнэлэх арга,
- EN ISO 105 Нэхмэл. Будгийн тогтвор шалгах туршилтууд. (бүх хэсгүүд),
- ГОСТ EN 340:2012 Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартуудын систем (ХАБСС). Тусгай зориулалтын хамгаалах хувцас. Ерөнхий техникийн шаардлагууд,
- ГОСТ 11209:2014. Тусгай зориулалтын хувцасны даавуу. Ерөнхий техникийн шаардлагууд. Туршилтын аргууд,
- ГОСТ 20272:2014 Химийн ширхэгтэн ээрмэл ба утсан дотрын даавуу. Ерөнхий техникийн шаардлагууд,
- ГОСТ 3813:72 (ИСО 5081-77, ИСО 5082-82) Нэхмэл материал. Даавуу ба ширхэгийн бүтээгдэхүүн. Суналтын үе дэх даацын үзүүлэлтүүдийг тодорхойлох аргууд (N 1, 2, 3 өөрчлөлтүүдтэй),

MNS 6706 : 2018

- MNS 6343:2012 “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын хувцасны ерөнхий ангилал, нэр төрөл, хэмжээ”,
- MNS 6344:2012 “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын хувцсанд тавигдах ерөнхий шаардлага”,
- MNS 1835-2 :2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м² жин тодорхойлох,
- MNS 1835-3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга,
- MNS 1835-4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга,
- MNS 1835-5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац, суналт тодорхойлох арга,
- MNS 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тэсвэрлэлт тодорхойлох арга,
- MNS 1836-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Бүрзийлт тодорхойлох арга,
- MNS 1835-8:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга,
- MNS 1835-9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Чийглэг тодорхойлох арга
- MNS 4535: 2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Агаар нэвтрүүлэлт тодорхойлох арга,
- MNS ISO14184-1:2016 Нэхмэл бүтээгдэхүүн. Формальдегид тодорхойлох усан экстракцын арга,
- MNS 4010:2009 Нэхмэл бүтээгдэхүүн. Ширхэгтийн бүрэлдэхүүн тодорхойлох арга,
- DIN EN 470/1 Чийг шингээлт тодорхойлох арга,
- MNS ISO 105-E01:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг усанд тодорхойлох арга,
- MNS ISO 105-E04:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга,
- MNS ISO 105-X12:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг үрэлтэнд тодорхойлох арга,
- MNS ISO 105-C10:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг угаалганд тодорхойлох арга,
- MNS ISO 105-D01:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг хими цэвэрлэгээнд тодорхойлох арга,
- MNS ISO 105-X11:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг индүүдлэгэнд тодорхойлох арга,
- MNS 0637:2009 Арьс шир. Боловсруулсан илгэн нэхий. Техникийн шаардлага,
- MNS 6295:2011 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний аюулгүй байдлын нийтлэг шаардлага.

3. Нэр томъёо, тодорхойлолт

3.1 Энэ стандартын нэр томъёо нь MNS 6343:2012 “Онцгой байдлын байгууллагын албан хаагчдын хувцасны ерөнхий ангилал, нэр төрөл, хэмжээ” стандартын нэр томъёотой тохирно.

3.2 Стандартад дараах тодорхойлолт бүхий нэр томъёо ашигласан болно.

3.2.1

хээрийн хувцас

онцгой байдлын алба хаагч хуульд заасан үндсэн болон тусгай үүрэг гүйцэтгэх, хээрийн сургууль дадлагад оролцох, харуул манаанд үүрэг гүйцэтгэх үед өмсөхөд зориулагдсан дүрэмт хувцас;

3.2.2

гадрын даавуу

хувцасны загвар, хэв маягийг илэрхийлэх, гадны нөлөөнөөс хамгаалах зориулалт бүхий хувцасны давхаргуудын хамгийн гадна талын давхарга;

3.2.3

дотрын даавуу

хувцсыг өмсөж тайлахад хялбар байлгах, хувцасны дотор талаасаа элэгдэлтээс болон сэмрэлтээс хамгаалах, үндсэн бүрдэл хэсгүүдийн хэлбэр хадгалалтыг хангах, бүтээгдэхүүний дотор талын үзэмжтэй байдлыг хангах зориулалт бүхий хувцасны давхаргуудын хамгийн дотор талын давхарга;

3.2.4

дулаалгын материал

хувцасны дулаан хадгалалтыг нэмэгдүүлэх зориулалт бүхий хувцасны давхаргуудын дундах давхарга;

3.2.5

ширхэгтийн бүрэлдэхүүн

нэхмэлийн бүрэлдэхүүнд байгаа ширхэгтүүдийн эзлэх хувь,%;

3.2.6

нэг метр квадратын жин

нэгж талбайд ноогдох нэхмэлийн сорьцын жинг 1м² талбайд шилжүүлж тооцсон жин, г/м²;

3.2.7

нэхээсний нягт

нэхмэлийн 10 см-т ноогдож байгаа хөндлөн тууш утасны тоо;

3.2.8

тасралтын даац

нэхмэлийн сорьцыг тасрах хүртэл зарцуулагдсан хүчний дээд хэмжээ, килограмм хүч;

3.2.9

тасрах үеийн харьцангуй суналт

нэхмэлийн сорьцын тасрах үеийн үнэмлэхүй суналт ба анхны уртын харьцаа, %;

3.2.10

норгосны дараах хэмжээний өөрчлөлт

нэхмэлийг норгосны дараах урт ба өргөний өөрчлөлт, %;

3.2.11**бүрзийлт**

нэхмэлийн гадаргуу дээр ширхэгтийн сул, богино үзүүр бөөгнөрч бөмбөлөг үүсгэх байдал (гэрлийн тусгалд сүүдэртэж харагдах), балл;

3.2.12**элэгдэл тэсвэрлэлт**

нэхмэлийг зориулалтын төхөөрөмжөөр эргэлдэх хөдөлгөөнөөр үрэхэд бөх бат байдлаа хадгалах чанар, эргэлтийн тоо;

3.2.13**чийг шингээлт**

нэхмэлийн агаар дахь харьцангуй чийгийг шингээх чадвар, %;

3.2.14**агаар нэвтрүүлэлт**

нэгж хугацаанд нэгж талбайгаар нэвтрэн өнгөрөх агаарын урсгалын хэмжээ, л/цаг/см²;

3.2.15**хүчил шүлтийн тэнцвэр**

нэхмэлийн усан экстрактын орчны хүчил шүлтийн тэнцвэр, балл;

3.2.16**формальдегидын агууламж**

нэхмэлийн усан экстрактын орчны хүчил шүлтийн тэнцвэрт 4,8-7,5 нөхцөлд байж болох формальдегидын хэмжээ, мг/кг;

3.2.17**усны үйлчлэл тэсвэрлэх чадвар**

нэгж хугацаанд тодорхой даралтаар үйлчлэхэд нэхмэлээр нэвтрэн гарч байгаа усны хэмжээ, балл;

3.2.18**будгийн тогтвор**

нэхмэлийн будгийн хөлс, үрэлт, ус, угаалга, индүүдлэг, хими цэвэрлэгээнд тогтвортой байх байдал, балл;

3.2.19**даавууны өнгөний Пантон (PANTONE) код**

өнгөний сонголт, ижилсүүлэлтийн стандартчлагдсан олон улсын систем бөгөөд текстилийн үйлдвэрлэлд ашигладаг Fashion+Home гэсэн 2100 өнгөнөөс бүрдсэн тусгай боловсруулсан стандарт дахь TPX (Т- текстилийн сан, Р- цаасан хэлбэрээр, Х- сүүлийн үе) ба ТСХ (Т- текстилийн сан, Р- цаасан хэлбэрээр, Х- хөвөн) индекс бүхий өнгөний код

3.2.20**өнгөлөн далдлалтын өнгө**

хүний биеийн силуэтийг орчны өнгөн дээр сарниулж, түүнтэй ижилсгэн харагдуулж мэдэгдэх байдлыг багасгадаг хувцас, хэрэгслийн тусгай өнгө;

3.2.21**өнгөлөн далдлалтын дижитал ACUPAT (Акупат) хээ**

ACUPAT (Army Combat Uniform Pattern) буюу Army Combat Uniform (ACU) гэж нэрлэгддэг, оливын-саарал, саарал-шар-ногоон, цайвар-хүрэвтэр-саарал гэсэн саарлын 3 өнгө-туяа бүхий тэгш өнцөгтүүд, жижиг квадратууд ба шаталсан ирмэгүүд бүхий том, жижиг дүрсүүдээс бүрдсэн хээ.

3.2.22**даавууны хээний раппорт**

даавууны хээ зурагт олон дахин давтан тохиолдох хээний хэсэг, суурь элемент

Ангилал**4.1 Даавууны ангилал****4.1.1 Хээрийн хувцасны даавууг зориулалтаар нь:**

- дулааны улирлын хувцасны даавуу (хүрэм, өмд, саравчтай малгай)
- хүйтний улирлын хувцасны даавуу.

4.1.2 Хүйтний улирлын хувцасны даавууг улирлаар нь:

- хавар намрын хувцасны даавуу (хүрэм)
- өвлийн хувцасны даавуу (хүрэм, өмд).


4.1.3 Дээрх хувцаснуудыг бэлтгэх бүх материалуудыг давхаргын бүтцээс хамааруулан:

- гадрын даавуу
- дотрын даавуу гэж ангилна.

5. Техникийн шаардлагууд**5.1 Даавууны нэр төрөл, артикул, хээ, өнгө нь батлагдсан загвартай тохирч байна.**

5.2 Хээрийн хувцасны гадрын даавуу нь 1-р зурагт заасан өнгөлөн далдлалтын дижитал ACUPAT (Акупат) хээтэй байна. Хээний өнгөний бүрэлдэхүүн: PANTONE систем дэх 19-0307 TPX код бүхий хар ногоон /Climbing Ivy/, 18-4105 TPX код бүхий саарал /Moon mist/, 15-1307 TPX цайвар шаргал /White pepper/.

5.3 Даавууны дижитал ACUPAT (Акупат) хээний раппорт нь 506мм*209мм хэмжээтэй ромбо хэлбэрийн раппорт байна.



1-р зураг. Хээрийн хувцасны өнгөлөн далдлалтын дижитал АСУРАТ (Акупат) хээний раппорт, раппортын хэмжээ, раппортоор хээ үүсгэсэн байдал.

5.4 Хувцасны дотрын даавууны өнгө нь гадрын даавууны өнгөтэй зохицсон байна.

5.5 Хээрийн хувцасны гадрын болон дотрын даавууны физик- механик, эдэлгээ, эрүүл ахуйн шинж чанарын үзүүлэлтүүд 1-р хүснэгтэд заасан шаардлагад нийцсэн байна.

Даавууны шинж чанарын үзүүлэлтүүд

1-р хүснэгт

| № | Үзүүлэлтийн нэр | Үзүүлэлтийн шаардлага | | |
|---|---|----------------------------------|---------------------------|--------|
| | | Гадрын | | Дотрын |
| | | Зуны | Хавар намрын болон өвлийн | |
| 1 | Ширхэгтийн бүрэлдэхүүн, %, багагүй | | | |
| | - Хөвөн | 60 | - | - |
| | - Полиэстер | 40 | 80 | 50 |
| | - Вискоз | - | 20 | 50 |
| 2 | 1м ² -ын жин, г/м ² , багагүй | 220+5 | 240 | 110 |
| 3 | Зузаан, мм, | 0,3-0,4 | 0,35-0,45 | - |
| 4 | Нэхээсний нягт, тоогоор, багагүй | | | |
| | - тууш | 315±2 | 440±2 | 530±2 |
| | - хөндлөн | 204±3 | 220±3 | 300±3 |
| 5 | Нэхээсний төрөл | Хосолсон, армир утастай рип-стоп | | Сарж |
| 6 | Тасралтын даац, кг хүч, багагүй | | | |
| | - суурь утасны дагуу | 100 | 102 | 20 |

| | | | | |
|---------------|---|------|-------|------|
| | - хөндлөн утасны дагуу | 107 | 71,4 | 16 |
| 7 | Суналт, %, ихгүй | | | |
| | - суурь утасны дагуу | 27 | 35 | - |
| | - хөндлөн утасны дагуу | 15 | 36 | - |
| 8 | Бүрзийлт, балл, багагүй | | | |
| | Эргэлтийн тоо | | | |
| | - 2000 | 4 | 4 | 4 |
| | - 5000 | 3-4 | 3-4 | - |
| | - 7000 | 3-4 | 3-4 | - |
| 9 | Элэгдэл тэсвэрлэлт, эргэлтийн тоо, багагүй | 7300 | 10000 | 1000 |
| 10 | Урагдалтын ачаалал, Н, (кг хүч) багагүй | | | |
| | - суурь утасны дагуу | 7,1 | 7,7 | 2,0 |
| | - хөндлөн утасны дагуу | 7,1 | 7,2 | 1,5 |
| 11 | Норгосны дараах хэмжээний өөрчлөлт, %, ихгүй | | | |
| | - суурь утасны дагуу | 3,5 | 3,5 | 4,0 |
| | - хөндлөн утасны дагуу | 2,0 | 2,0 | 2,0 |
| 12 | Будгийн тогтвор, балл, багагүй | | | |
| | - хөлсөнд | 4 | 4 | 4 |
| | - угаалгад | 4 | 4 | 4 |
| | - хуурай үрэлтэд | 4 | 4 | 4 |
| | - нойтон үрэлтэд | 4 | - | 3 |
| | - гэрлийн үйлчлэлд | 5 | 4 | - |
| | - химийн цэвэрлэгээнд | 4 | 5 | - |
| | - органик уусгагчид | 4 | - | 5 |
| - индүүдлэгэд | 4 | 4 | 4 | |
| 13 | Чийг шингээлт, %, доошгүй | 4 | - | 10 |
| 14 | Агаар нэвтрүүлэлт, дм ³ /м ² с, багагүй | 35 | 20 | 60 |
| 15 | Формальдегидийн агууламж, мг/кг, ихгүй | 75 | 300 | 75 |
| 16 | Ус түлхэх чадвар, багагүй, нэгж | 90 | 90 | - |
| 18 | Сэмрэлт, мм, ихгүй | 1 | 1 | 2,5 |

5.6 Хээрийн хувцасны гадрын болон дотрын даавууны технологийн шинж чанарын үзүүлэлт 2-р хүснэгтэд заасан шаардлагад нийцсэн байна.

Гадрын болон дотрын даавууны технологийн шинж чанарын үзүүлэлтүүд

2-р хүснэгт

| № | Үзүүлэлтийн нэр | Үзүүлэлтийн шаардлага | | |
|---|--|-----------------------|--------|------|
| | | Гадрын | Дотрын | |
| 1 | Материалын өргөний хазайлтын хэмжээ, см, багагүй | ±2,0 | ±2,5 | |
| 2 | Даавууны эн тус бүрийн өргөн, см, ихгүй | 1,7 | 1,7 | |
| 3 | Угаасны дараах хэмжээний өөрчлөлт, %, ихгүй | | | |
| | | -тууш утасны дагуу | -0,5 | -3,5 |
| | | -хөндлөн утасны дагуу | -1,0 | ±2,0 |
| 4 | Утасны шилжилт эсэргүүцэлт, кг хүч, багагүй | | 98 | |
| 5 | Сэмрэлт, мм, багагүй | | 2,5 | |

5.4.3 Даавуу нь 1-р зэргийн даавуунд зөвшөөрөгдсөнөөс хэтэрсэн согоггүй байна.

6. Даавууны хаяглалт, хүлээн авалт, хадгалалт, тээвэрлэлт

6.1 Даавууны хаяглалт

Даавууны шошго нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр болон бүтэн нэр,
- Даавууны нэр, артикул,
- Даавууны өнгө,
- Даавууны хэмжээ,
- Ширхэгтийн бүрэлдэхүүн,
- Гүйцэтгэн боловсруулалтын төрөл,
- Зэрэг,
- Стандартын дугаар,
- Үйлдвэрлэсэн огноо.

6.2 Хүлээн авалт

6.2.1 Хувцасны гадар, дотрын даавууны чанарыг захиалагч байгууллагын нөхцөл болон энэ стандартад заасан үзүүлэлт, шаардлага, баталсан загварын дагуу шалгаж хүлээн авна.

6.2.2 Даавууг уртын дагуу хуйлан хорхой, шавьжнаас хамгаалах бодис завсар нь хийж, ус, чийг, тоосноос хамгаалсан зориулалтын материалаар ороож битүүмжлээд нэг боодол болгож ирүүлсэн байна.

6.2.3 Гадар давхаргын даавуунд утас болон өнгөний жигд бус байж болохгүй.

6.2.4 Даавууны чанарыг хүлээн авах явцад захиалагч, ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагуудын хооронд гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

6.3 Хадгалалт

6.3.1 Даавууг хорхой шавьж, ус, чийг, тоосноос хамгаалсан зориулалтын материалаар ороож битүүмжлэн, шалнаас 15-аас 20 см өндөрлөсөн хөлтэй тавиур дээр хананаас 50 см зайд байрлуулж, (60-65) %-н чийгшилтэй, (16-18)⁰С температуртай зориулалтын орчинд хадгална.

6.3.2 Даавууг хадгалах хугацаанаас хамааруулж жилд нэгээс доошгүй удаа хортон шавьжны ариутгал хийнэ.

6.4 Тээвэрлэлт

6.4.1 Даавууг ус, чийг, тоосноос хамгаалсан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.

А ХАВСРАЛТ (Мэдээллийн)

Хээрийн хувцасны AcuPat хээний раппорт, түүний хэмжээ, раппортуудыг нийлүүлсэн байдал

